

Г.Сарантуяа

МУИС-ийн СССУХ-ны тэнхимийн эрхлэгч, доктор, профессор

Ц.Цэцэнбилэг

ШУА-ийн ФСЭЗХ-ийн социологийн секторын эрхлэгч, доктор

Ж.Пүрэвханд

ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ, ЭРХ МЭДЛИЙН ХУВААРИЛАЛТ

Abstract: The paper is exploring modern urban family situation through family's power distribution and function differentiation. The authors based on statistical data, own survey conducted on 1000 Ulaanbaatar' inhabitants, psychological projective tests, such as tree design and Rorschach test, discuss modern family issues and types.

Key words: marriage, family relationships, types of family, modern family.

Нийгэм эдийн засгийн байдал хувьсаж өөрчлөгдөхийн хирээр гэр бүл бүрэлдэх явц, гэр бүлийн нийгмийн харилцаа өөрчлөгдөж ирсэн. Гэр бүлийн хөгжил хэлбэржилтэнд нийгэм шууд нөлөө үзүүлдэг бөгөөд гэр бүл эргээд нийгмийн харилцаанд тусгалаа олдог бие биенээсээ харилцан нөлөөлсөн нийгмийн анхдагч институт. Дэлхий нийтийн гэр бүл, гэр бүлийн харилцааны ерөнхий чиг хандлагыг авч үзвэл гэр бүлийн гишүүдийн үүрэг, эрх мэдлийн өөрчлөлт, хожуу гэрлэлт, эрт бэлгийн харилцаанд орох, гэрлэхээс илүүтэй хамтран амьдрахыг чухалчлах, олон нөхөртэй, олон эхнэртэй байх нь амьдрал дээр нуугдмал хэлбэрээр оршин байж, мөн төрөлт буурах, гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаанд орох, ижил хүйстний зэрэг өрөөсгөл гэр бүл, салалт, ихсэж байгаа болно. Дэлхий нийтийг хамарч буй даяаршил болон 1990 оноос хойш Монголын нийгэмд эрчимтэй өрнөсөн нийгмийн өөрчлөлт, шинэчлэлийн үйл явцын нөлөөгөөр гэр бүл, гэр бүлийн харилцаа хувьсан өөрчлөгдөж байна. Монголын гэр бүл дэх уламжлал шинэчлэл, үнэт зүйлийн чиг баримжаалал алдагдсанаар өнөөгийн гэр бүл дэх салалт, гэр бүлийн хүчирхийлэл гэх мэтийн сөрөг зүйл ихээхэн гарах болсон нь биднийг орчин үеийн монгол гэр бүлийн харилцааны ерөнхий байдал, чиг хандлагыг авч үзэхэд хүргэсэн юм. Ингэхдээ орчин үеийн монгол гэр бүлийн харилцааны ерөнхий байдал, чиг хандлагыг гэр бүлийн гишүүдийн үүрэг, эрх мэдлийн хуваарилалтын өөрчлөлтөөр нийслэлчүүдийн жишээн дээр гаргаж ирэхийг энэ итгэлдээ зорьсон болно.

Манай улсын хувьд гэр болох чиг хандлага ямар байсныг авч үзвэл дайн самуун үймээнтэй байсан 1930-аад оны үед монголчуудын гэр бүл болох түвшин доогуур байсан. Гэрлэлтийн талаар тодорхой тоймтой тоо баримт байхгүй ч тухайн үед болж байсан үйл явдал нь гэр бүл болох түвшин бага байхын үндэс болж байв. Тухайлбал: 1935-1944 оны онд хүн амын тоо 738,2-759,1 мянга байсан. Жил бүр дунджаар 80000 орчим эрчүүдийг цэргийн албанд татаж байсан бол насанд хүрсэн нийт эрчүүдийн 40 орчим хувь нь нөхөргүй байсан байна. Энэхүү байдал нь хүн амын төрөлт болон өсөлтөнд үлэмж сөрөг нөлөө үзүүлж байсан нь ойлгомжтой. 1960-аад оноос эхлэн төрөөс хүн ам, нийгэм эдийн засгийн талаар тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд гэр бүлгүй хүн амын тоо багасаж, хүйсийн харьцаа тодорхой хэмжээгээр тогтворжих хандлага ажиглагдаж эхэлсэн байна. 1979 оны тооллогоор арван тав, түүнээс нийт хүн амын 65,4 хувь нь гэр бүлтэй байсан бол 1989 онд 65,8 хувь, 2000 онд 57,8 хувь, 2010 онд 60,1 хувь болсон байна.¹ Хүн ам орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр Монгол Улсын суурин хүн амын 96,5 хувь нь 713,8 мянган өрхөд тоолуулсан.² Мөн анхны гэрлэлтийн дундаж насыг тухайн насны бүлгийн хүн амд эзлэх огт гэр бүл болоогүй хүн амд үндэслэн тооцдог. Арван тав, түүнээс дээш насны хүн амд огт гэр бүл болоогүй хүн ам 1979 онд 23 хувь, 1989 онд 25,3 хувь, 2000 онд 33,1 хувь, болж өссөөр байсан бол 2010 онд өмнөх үеэс 1,8 хувиар буурсан байна. Энэ нь 2007-2008 онд төрөөс залуу гэр

¹ Хүн ам, орон сууцны тооллогын үндсэн үр дүн. ҮСХ, 2010.30 дахь тал.

² Хүн ам, орон сууцны тооллогын үндсэн үр дүн. ҮСХ, 2010. 2 дахь тал.

бүлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд залуучууд гэр бүл болох нь нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм. 1979 оны тооллогоор арван тав, түүнээс дааш насны эрэгтэйчүүдийн 27,7 хувь нь огт гэрлээгүй байсан бол өссөөр 2010 онд 28,2 хувьд хүрсэн байна. Огт гэрлээгүй, эрэгтэй эмэгтэйчүүдийн тоо жилээс жил өссөөр байгаа хэдий ч огт гэрлээгүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа нөхөрт гардгийг харуулж байна. Тиймээс ч эмэгтэйчүүдийн анхны гэр бүл болох дундаж нас эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага байдаг байна. Огт гэр бүл болоогүй эрэгтэй, эмэгтэйчүүдийн 70-аас багагүй хувь нь эхний хоёр насны бүлэг буюу 15-24 насны бүлэгт хамрагдаж байна. Огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн дотор 15-19 насны бүлгийн эрэгтэйчүүд хожуу гэрлэх хандлагатай болсныг харуулж байна.

Арван тав түүнээс дээш насны огт гэр бүл болоогүй хүн амын 74 хувь нь хотод байна. Энэ нь нэг талаараа хотод оюутан суралцагсад сурахаар шилжин ирдэг, хүн амын төвлөрөл ихтэй зэрэгтэй холбоотой юм. Хөдөө, хотын алинд нь огт гэрлээгүй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс их байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа гэрлэдэг гэсэн дээрх үр дүнг батлан харуулж байна. Огт гэрлээгүй хүн амыг байршлаар, хүйсээр, насаар ангилан үзэхэд ангилал ялгаагүй 15-24 насныхан давамгайлж байгаа нь залуучууд 24 хүртэлх насандаа гэр бүлтэй болох нь багас ч байгааг харуулж байгаа юм. Залуучууд гэр бүл болохоосоо өмнө боловсрол, эзэмших, ажил эрхлэх, тогтмол орлоготой болохыг эрхэмлэх болсонтой холбон тайлбарлаж болно. Мөн 25-54 насны эрэгтэй, эмэгтэйчүүдийн салах хувийн жин өндөр байна. 2010 онд өмнөх тооллоготой харьцуулахад 39 хүртэлх насны эрэгтэйчүүдийн салах нь багассан, 40-өөс дээш насны эрэгтэйчүүдийн салалт нэмэгдсэн, эмэгтэйчүүдийн хувьд 40-өөс дээш насныхны салалт нэмэгдсэн нь гэр бүл салах нас хойшилж байгааг харуулна. Үзүүлэлтийг байршлаар нь үзвэл 2010 онд цуцалсан болон тусгаарласан хүн амын 80,4 хувь нь хотод, 19,6 хувь нь хөдөөд байна.¹

Анхны гэрлэлтийн дундаж насны хувьд хөдөөгийн залуус хотынхоос арай эрт гэрлэдэг бөгөөд ялангуяа хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн гэрлэлтийн дундаж насны зөрүү нэлээд байна. Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр хотын эмэгтэйчүүд дунджаар 25 насандаа анх гэрлэж байхад хөдөөд 22 насандаа гэрлэж байна. Гэтэл эрэгтэйчүүдийн хувьд хот, хөдөөгийн ялгаа бараг байхгүй бүгд дунджаар 26 насандаа анх гэрлэж байна. 1979 оны хүн ам, орон сууцны тооллогоос хойших хугацаанд хөдөөгийн эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас 4,1 жилээр хойшлогдсон бол хотын эмэгтэйчүүдийнх бүр 5,4 жилээр хойшилсон байна.² XX зууны эхэн үед гэхэд эрийн цээнд бүрэн хүрсэн, бие дааж чадсан эр хүн цэл залуу хүүхнийг эхнэрээ болгон авдаг байсан бол өнөөдөр нөхөр нь эхнэрээсээ насаар дүү гэр бүлийн эзлэх хувь үлэмжхэн өөрчлөгдсөн, Монголын гэр бүлийн өнөөгийн байдлын судалгааны дүнгээс үзвэл:

- Гэр бүлтэй нийт хүн амын 12.8 хувийг хамтран амьдрагч буюу хууль ёсоор гэрлэлтээ батлуулаагүй хүмүүс эзэлж байгаа бөгөөд ихэвчлэн 20-35 насныхны дунд зонхилж байна.
- 15-аас дээш насныхны дунд гэрлээгүй хүн амын эзлэх хувь нэмэгдэж, 1989 онд гэрлэх насны 4 хүн тутмын нэг, 2000 онд 3 хүн тутмын нэг нь огт гэрлээгүй байна. Анхны гэрлэлтийн нас хойшилж, эрэгтэйчүүд 26, эмэгтэйчүүд 24 насандаа тус тус гэрлэх болжээ.
- Өрх толгойлсон эмэгтэйчүүд 43.8 хувь, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 34.8 хувь нь ядуу байна. Ядуу өрхийн 12-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин 67 хувь байна.
- Дээд боловсролтой 35-49 насны эмэгтэйчүүдийн 25.0 орчим хувь, 20-34 насны эмэгтэйчүүдийн 46.0 хувь нь өөрөөсөө доогуур түвшний боловсролтой эрэгтэйтэй гэрлэжээ.
- 1989-2000 онд гэр бүлээ цуцлуулсан хүний тоо 2 дахин их нэмэгдсэн бөгөөд энэ байдал 30-44 насныхны дунд өндөр байна.
- Гэр бүл салалтын шалтгааны 54.0 хувь нь итгэл алдарсан, 47.3 хувь санхүүгийн бэрхшээлтэй, 41.3 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг гэсэн байна. Гэр бүлээ цуцлуулсан өрхийн 70.0 хувь нь 0-15 насны хүүхэдтэй байна.³

Бид энэхүү илтгэлийг бичихдээ 2010-2011 онуудын зааг дээр ШУА-ийн ФСЭЗХ-ийн социологийн сектор, МУИС-ийн Улаанбаатарын сургуулиас олон шатлалтай санамсаргүй түүврийн аргаар Улаанбаатар хотын 6 дүүргээс бүтэцлэгдсэн сурвалжлагын аргаар зохион

¹ Хүн ам, орон сууцны тооллогын үндсэн үр дүн. 2010 он.38 дахь тал


² Хүн ам, орон сууцны тооллогын үндсэн үр дүн. 2010 он. 44 дахь тал

³ “Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” суурь судалгаа.УБ., 2004.

байгуулж 1000 хүнээс авсан мэдээлэл¹, 27 хүний модны тест, Роршахын тестийн² үр дүн ашигласан болно. Энэхүү илтгэлдээ бид нийслэлчүүдийн гэр бүлийн эрх мэдэл, үүргийн хуваарилалтын ерөнхий байдал, мөн 27 хүний гэр бүлийн эрх мэдэл, үүргийн хуваарилалтын тэдний сэтгэл зүйн байдалтай харьцуулахыг оролдсон болно.


Судалгаанд оролцогчдын 60,34% нь батлуулсан гэр бүлтэй, 29,31% нь огт гэр бүл болоогүй гэж хариулжээ.

График 1. Гэр бүлийн байдал



Батлуулан гэр бүлтэй эрэгтэйчүүд 60,34%, эмэгтэйчүүдийн 54,1%, батлуулаагүй гэр бүлтэй эрэгтэйчүүдийн 8,19%, эмэгтэйчүүдийн 11,57%, огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн 23,31%, эмэгтэй 27 хувьтай байна.

График 2. Гэр бүлгүй байгаа шалтгаан



Судалгаанд оролцогчид одоогоор гэр бүлгүй шалтгаанаа гэрлэх насанд хүрээгүй эрэгтэй 36,23%, эмэгтэй 38,10%, сэтгэлд нийцсэн хүнтэйгээ учраагүй эрэгтэй 28,26%, эмэгтэй 18,45% гэрлэх насанд хүрсэн ч яарахыг бодохгүй байна гэж эрэгтэй 23,19%, эмэгтэй 27,98% хариулсан нь өнөөгийн залуучууд амьдралын үнэ цэнийг ойлгож, өөрийн гэсэн үл хөдлөх хөрөнгөтэй хэнээс ч дутахааргүй сайхан амьдрах чадвартай болсон хойноо гэр бүлтэй болохыг илүүд болжээ.

1990 оноос хойш иргэд хувийн өмчтэй байх, худалдаа наймаа, бизнес, өрхийн аж ахуй эрхлэх бүрэн боломжтой болсон. Гэтэл хүний амьдралын зайлшгүй хэрэгцээ болсон хоол хүнс, өргөн хэрэглээний бараа, хувцас хэрэглэлийн үнэ өртөг өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь гэр бүлд эдийн засгийн хүнд дарамт болж байна. Өнөөдөр ихэнхи гэр бүлийн нийт орлогын дийлэнхи нь хоол хүнс, хувцас зэрэгтээ зарцуулагдаж байна. Бусад зардал сурч боловсрох, эрүүл мэнд, ахуй байдлаа дээшлүүлэх зэрэгт тэр бүр олж байгаа орлого нь хүрэлцэхгүй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 1. Материаллаг байдлыг насаар харьцуулсан үзүүлэлт

	18-24	25-34	35-44	45-64	65-с дээш	нийт

¹ Судалгааны мэдээлэл цуглуулсан МУИС-ийн Улаанбаатарын сургуулийн социологи-нийгмийн ажилтны ангийн оюутнауд талархал илэрхийлье.


² Энэхүү аргуудыг сургаж үнэтэй зөвлөгөө өгсөн Франц улсын Парис 10 Их сургуулийн судлаач Хэлэн Салан Де Куртангүс, “Сэтгэлийн толь” сэтгэл зүйн төвийн захирал Х.Хандсүрэнд мөн гүн талархлаа илэрхийлье.

Материаллаг байдал	3.89	3.87	3.87	3.79	3.75	3.85
Хооллолт	4.18	4.13	4.17	3.93	4.03	4.11
Хувцаслалт	4.07	3.92	4.03	3.89	3.88	3.98
Эрүүл мэнд	4.07	3.92	4.05	3.82	3.75	3.96
Орон сууцны нөхцөл	3.73	3.67	3.81	3.64	3.53	3.70
Дуртай ажилдаа орох бололцоо	3.61	3.39	3.38	3.35	3.16	3.44
Мэргэжил боловсролыг дээшлүүлэх бололцоо	3.84	3.47	3.45	3.29	3.22	3.53
Гэр бүлийн харилцаа	4.28	4.08	4.26	4.18	4.08	4.20
Амьдрал бүхэлдээ	3.96	3.79	3.93	3.87	3.75	3.88

Судалгаанд оролцогчид амьдралынхаа дараах байдлыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултанд дээрхи байдлаар хариулжээ. 18-24 нас, 35-44 насныхан хооллолт, хувцаслалт, эрүүл мэндээ сайн мөн гэр бүлийн харилцаа бүх насныхан сайн буюу маш сайн гэж үнэлгээ өгчээ. Харин материаллаг байдал, орон сууцны нөхцөл, дуртай ажилдаа орох бололцоо, мэргэжил боловсролыг дээшлүүлэх бололцоогоо дунд гэж үнэлсэн нь 1990 оноос хойш иргэд хувийн өмчтэй байх, худалдаа наймаа, бизнес өрхийн аж ахуй эрхлэх бүрэн боломжтой болсон. Гэтэл хүний амьдралын зайлшгүй хэрэгцээ болсон хоол хүнс, өргөн хэрэглээний бараа, хувцас хэрэглээний үнэ өртөг өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь гэр бүлд эдийн засгийн хүнд дарамт болж байна. Өнөөдөр ихэнхи гэр бүлийн нийт орлогын дийлэнхи нь хоол хүнс, хувцас зэрэгтээ зарцуулагдаж байна. Бусад зардал болох сурч боловсрох, эрүүл мэнд, ахуй байдлаа дээшлүүлэх зэрэгт тэр бүр олж байгаа орлого нь хүрэлцэхгүй байгаа нь харагдаж байна.¹

Судалгаанд оролцсон гэр бүлийн аж байдлыг товч илтгэсний дараа үндсэн асуудал болох гэр бүлийн гишүүдийн эрх мэдэл, үүргийн хувиарилалт, гэр бүлийн янз бүрийн хэлбэрүүдийн онцлог зэргийн авч үзье.

График 3. Гэр бүлийн асуудлыг хэн ихэвчлэн шийддэг вэ?




Гэр бүлийн асуудлыг хэн ихэвчлэн шийддэг вэ? гэсэн асуултанд манай судалгаанд оролцогчдоос эхнэр, нөхрийн хамтын шийдвэр, гэр бүлийн хамтын шийдвэр гэж хариулсан нь дийлэнх байгаа бөгөөд тэдгээр нь 18-24 насны хүмүүс буюу залуучууд байгаа нь, мөн хүүхдийн саналыг чухалд үзэж байгаа нь 45-64, 25-34 насны хүмүүс байгаа уламжлалт гэр бүлийг харилцан тэгш эрхт гэр бүлээр сольж байгааг харуулж байна. Үүний дараагаар ахмад настны үгийг гол болгодог гэр бүл буюу эцэг эх ахмадуудын тэргүүлэлтэй гэр бүл байгаа юм. Эдгээр нь цагийн

¹ “Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” суурь судалгаа.УБ., 2004.


аясаар өөрчлөгдөж байдаг нийгэм, хүмүүсийн сэтгэлгээтэй холбоотой ба орчин үед чөлөөт, харилцан тэгш эрхтэй байх ёстой гэдэг зүйл давамгайлж байгаагийн тод жишээ юм.

График 4. Таны бодлоор гэр бүлд хэн өрхийн тэргүүлэгч байх ёстой вэ?



Монголчуудын өнөөгийн нийгэмд эмэгтэй хүн зөвхөн хүүхэд төрүүлэх, гэрийн ажил хийх, хоол хийх зэргээс илүүтэйгээр ажил хөдөлмөр эрхэлж эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүд амьдралаа авч явах ёстой гэсэн ойлголт гарсан. Таны бодлоор гэр бүлд хэн өрхийн тэргүүлэгч байх ёстой вэ? гэсэн асуултанд сүүлийн үед өрх толгойлсон эмэгтэйчүүд их байгаатай холбоотойгоор эхнэр гэж хариулсан эмэгтэйчүүдийн 59,3%, эрэгтэйчүүдийн 40,7% нь мөн орлогын эх үүсвэрийн ихэнхийг олдог хүн гэж эмэгтэйчүүдийн 52,9% гэж байгаа нь эмэгтэйчүүд ар гэр амьдралаа өөрсдөө авч явдаг нь харагдаж байгаа юм. Үүний дараагаар өрхийн ахмад настан гэж эмэгтэйчүүдийн 54,8%, эрэгтэйчүүдийн 45,2% гэж хариулсан нь одоо ч ахмадуудын үгийг сонсох хэрэгтэй Ахмадын үг бол алт гэдгийн нэг илрэл юм. Харин харилцан тэгш эрхтэй өрхийн тэргүүлэгч нь Хэн ч байж болно гэж эмэгтэйчүүдийн 51%, эрэгтэйчүүдийн 49% нь хариулсан байна.

График 5. Өрхийн тэргүүлэгч ямар үүрэг хүлээх ёстой вэ?



Өрхийн тэргүүлэгч ямар үүрэг хүлээх ёстой вэ гэсэн асуултанд өрхийн мөнгө тооцоог хийдэг байх гэж 10,5%, орлогын эх үүсвэрийн ихэнхийг олдог байх гэж 16,1%, ухаалаг овсгоотой байх гэж 16%, гэр орны ажлыг зохицуулдаг байх гэж 8,5%, боловсрол мэдлэгтэй байх гэж 18,4%, хариуцлага хүлээх чадвартай байх гэж 17,9% нь хариулсан байна.


Сүүлийн үеийн залуус заавал ахмад настан эцэг эхээрээ хэлүүлж байж сурахаас илүү өөрсдөө юмыг сурья, мэдлэг боловсролтой болъё гэсэн хүсэл эрмэлзэлтэй холбоотойгоор айл гэрийн өрхийн тэргүүн нь мэдлэг боловсролтой хэн хүнээс дутахааргүй байх ёстой ба сургууль соёлд сурч чаадаагүй ч гүйлгээ ухаан сайтай ухаалаг, овсгоотой, санхүүгийн асуудлаа шийдвэрлэж чаддаг, орлогынхоо эх үүсвэрийн ихэнхийг олдог байх үүнийг дагаад хариуцлагатай үр хүүхэд, хойч үеийнхнийхээ төлөө хийж бүтээсэн юмтай хариуцлагатай байж чаддаг байх нь л өрхийн тэргүүлэгчийн хүлээх үүрэг гэж үзэж байгаа юм.

Бид гэр бүлийн гишүүдийн асуудал шийдвэрлэх, гүйцэтгэх үүргээр гэр бүлийн хэв маягийн индексийг бодохыг оролдсон болно. Индекс үүсгэхдээ нөхөр ихэвчлэн асуудлыг шийдэж, өрхийн тэргүүлэгч нь байх юм бол түүнийг патриархал буюу уламжлалт гэр бүл, эхнэр асуудлыг шийдэж, өрхийн тэргүүн байх юм бол матриархал, эхнэр нөхрийн хамтын шийдвэрээр асуудлаа шийдэж байх юм бол ардчилсан буюу орчин үеийн гэр бүл, гэр бүлийн үүрэг хуваарилалын талаар тодорхой ойлголтгүй бол тодорхой бус, асуудлыг хэн ч шийдэж болно гэж үзсэн бол тохиолдлын

гэр бүл, өрхийн тэргүүлэгч нь ахмад настан байвал ахмад настнаа гол болгосон гэр бүл гэж тус тус ангилсан байгаа.

Манай судалгаанд оролцогчдын 32,1% нь ардчилсан гэр бүл, 25,2% хувь нь патриархал гэр бүл, 21,3% нь ахмад настнаа гол болгодог гэр бүл, 13,8% нь тохиолдлын гэр бүл, 5,9% нь тодорхой бус, ойлголтгүй гэр бүл, 1,7% нь материархал гэр бүлийг зохиосон байна. Өнөө үед ардчилсан гэр бүл ихэнх хувийг эзлэх болжээ. Энэ нь одоо үед ардчилал, даяаршил, орчин үеийн нийгэм, соёл зэрэгтэй холбоотой юм.


График 6. Гэр бүлийн хэв маягийн үүрэг хүлээж буй байдал



Өрхийн тэргүүлэгчид нь орлогын эх үүсвэрийн ихэнхийг олдог, ухаалаг овсгоотой, өрхийн мөнгө тооцоог хамтдаа барьж байх мэдлэг боловсролтой байх нь хамгийн их хувиар ардчилсан гэр бүл илүүд үздэг байна. Үүний зэрэгцээ уламжлалт болон ахмад настнаа гол болгодог гэр бүл ч байгаа юм. Энэ хоёр гэр бүл нь өрхийн тэргүүлэгч нь орлогын эх үүсвэрийн ихэнхийг олдог, ухаалаг овсгоотой, өрхийн мөнгө тооцоог хамтдаа барьж, мэдлэг боловсролтой болох хэрэгтэй гэж үзэж байгаа ч ардчилсан гэр бүлийг бодвол арай арай бага хувийг эзэлж байгаа юм. Бидний өвөө эмээ нар мэдлэг боловсролтой бол гэж их захидаг байсан. Залуус мөн өөрсдөө боловсролтой болохыг илүү хичээдэг болсон нь манай судалгаанаас харагдаж байна. Товчоор хэлбэл, одоо үед ардчилсан буюу чөлөөт, харилцан тэгш эрхтэй гэр бүл, мөн уламжлалт буюу эцгийн эрх давамгайлсан гэр бүл байгаа ч, ахмад настны үгийг ёсчлон дагадаг ёсон нь одоог хүртэл алдагдаагүй байгаа юм. Эдгээрээс гадна бидний амьдрал дээр тохиолдлын гэр бүл, тодорхой бус гэр бүл, тодорхой бус ойлголтгүй гэр бүл, мөн материархал гэр бүл зэрэг нь цөөнх болон оршсоор байна.

Манай судалгаанд оролцогчдын гэр бүлийн гишүүд хамтдаа хоолоо хийдэг байх ёстой, үр хүүхдээ харж анхаардаг байх, гэрийн ажлыг хийдэг, хогоо хаяж хувцасаа угаах, хувцас эд зүйл худалдан авах, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндэд анхаарах, боловсролоо дээшлүүлэхэд анхаарах, эцэг эх, өндөр настнаа анхаарах ёстой гэж үзсэн бол эцэг эх нь өрхийн төсөв, зардлыг тооцох, орлого олох ёстой гэж үзсэн байна. Үүнээс харахад эдгээр бүх ажлуудыг гэр бүлийн бүх гишүүд хамтдаа хийх ёстой гэж үзээд байгаа нь Улаанбаатар хотын ихэнх гэр бүлүүд уламжлалт хэв маягийг орхиод ардчилсан гэр бүлийг зохиож байгаатай холбоотой юм.

График 7. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүлийн хэв маяг



Манай судалгаанд оролцогчдыг хүйсээр нь гэр бүлийн хэв маягаар үзвэл:

- Эрэгтэйчүүд: ардчилсан, патериархал, ахмад настнаа гол болгодог, тохиолдлын, тодорхой бус, материархал гэж
- Эмэгтэйчүүд: Мөн адил ардчилсан, патериархал, ахмад настнаа гол болгодог, тохиолдлын, тодорхой бус, материархал гэж хариулсан байгаа ч эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээсээ илүү хувьтай байгаа юм. Энэ нь мөн өрхийн тэргүүн эрэгтэйчүүд ганцаараа илүү шийдвэр гаргадаг нь багасаж ардчилсан хамтач гэр бүл илүү болсоныг харуулж байна.

Бид түүнчлэн бүтэцлэгдсэн сурвалжлагыг нэмэлт 27 хүнээс сэтгэл зүйн аргуудтай хослуулан авсан болно. Энэ бүтэцлэгдсэн сурвалжлаганд оролцогчдын 26,7% нь патериархал, 33,3% нь ардчилсан, 26,7% нь тохиолдлын, 6,7% нь тодорхой бус, ойлголтгүй гэр бүлүүд байна.

Сэтгэлзүйн тестэнд оролцогчдоо харьцуулан үр дүнг нь гаргаад доорх 4 хэв маягт хуваав. Үүнд :

1 хэв маяг буюу сэтгэлийн түгшүүртэй байдал. Их тогтворгүй, өөртөө итгэлгүй айдас ихтэй. Ямар нэг зүйлээр дутагдаж сэтгэл санааны гүн хямралтай. Мөн өөрийн хүрээлэн буй орчноо бодитойгоор харахаас татгалздаг. Түшиг тулгуур их эрж хайсан. Амьдралдаа ихээр гутарсан, энэ байдалдаа өөрийгөө болон бусдыг буруутгадаг аливаа зүйлд нэгэн хэвийнээр ханддаг. Бодит байдал дээр хэрхэн биеэ авч явах нь харагддаг. Уналтаас их айдаг, гэр бүлд нь асуудалтай өөрийн дургүй зүйлээ их эсэргүүцдэг их нуугдмал, бүхнийг мэдэхийг хүсдэг. Өөрийгөө гээгдсэн мэтээр үздэг сэтгэлээр унасан. Гэсэн хэдий ч бусадтай нээлттэй харилцдаг. Таалагдахгүй зүйлээсээ зайлсхийдэг. Өөрийн алдааг засч нуухыг хүсдэг аливаа зүйлд сэтгэл хангалуун бус гэвч их уян зөөлөн, уналтаас их айдаг. Ээждээ их хайртай хүрээлэн буй орчноо бодитоор харахаас айдаг гэр бүл нь асуудалтай. Ийм онцлогтой хүмүүс гэр бүлээ зүгээр л тохиолдлоор сонгосон нь харьцуулалтаар харагдаж байна.

2 хэв маяг буюу хичээнгүй байдал. Энэ хүн хийсвэрлэж сэтгэх танин мэдэхүйн хэв маягтай ерөнхий зарчмын асуудлыг их сонирхдог. Ямар нэг юмаар дутагдсан. Өөр хоорондоо болон бусадтай зөвшилцөх, тэнцвэрт байдлыг эрж олох хүсэлтэй. Бусадтай нээлттэй харилцдаг мөн дэмжлэг их хэрэгтэй. Товч тодорхой байдлыг их эрж хайдаг. Зөн билэг нь их хөгжсөн. Сайхан амьдрахыг их хүсдэг дутагдаж байгаа зүйл нь мөнгөөр хязгаарлагдаж байх талтай. Аливаа асуудлыг сэтгэл хөдлөлөөр биш оюун ухаанаар шийдэхийг их чухалчилдаг. Их тэнцвэртэй байдаг. Сэтгэл санаагаар дэмжлэг авахыг их хүсдэг. Ийм онцлогтой хүмүүс орчин үеийн гэр бүл буюу ардчилсан гэр бүлийг сонгосон байна.

3 хэв маяг буюу сэтгэлийн тэнхээтэй байдал. Өнгөрсөн үедээ илүү их хайртай. Уур бухимдал ихтэй өөрийгөө гээгдсэн мэтээр мэдэрч сэтгэлээр унасан. Өөрийнхөө алдааг засч нуухыг хүсч байгаа биеэ даасан байдлаа хадгалах өөрийн хариу үйлдлээ барих чадвартай. Бусадтай нээлттэй харилцдаг авах өгөх чадвартай. Амьдрал нь унах вий гэхээс их айдаг. Өнгөрсөн амьдрал хүүхэд насны дурсамж өнгөрсөндөө очих хүсэлтэй. Ерөнхийлөн дүгнэх чадвартай. Бодох бодол ихтэй боловч түүнийгээ давах чадвар байгаа нь харагддаг. Урьд нь гэр бүлийн амьдралд асуудал

тулгарч байсан нь харагдаж байна. Үүнээсээ их айж амьдрал нь сүйрч унах вий гэхээс их айдаг. Ийм сэтгэлзүйн онцлогтой хүмүүс патериархал буюу уламжлалт гэр бүлийг сонгосон байна.

4 хэв маяг буюу өөртөө итгэлгүй байдал. Өөрийн дотоод байдал нь их зожиг аймхай, биеэ барих зориггүй, юм хийх санаачлага зориггүй. Тогтвортой өөртөө итгэлгүй. Мөн ээжтэйгээ харилцах харилцааг бага насныхаа тухай их боддог. Гэр бүлийнхнийгээ гэсэн сэтгэлтэй тэдэнтэйгээ их дотно байдаг. Ердийн нөхцөл байдалд өөрийгөө хэрхэн авч явах өөрийнхөө хэн юм бэ? гэдгээ харуулах тал дээр муу бусадтай харилцах харилцаа маш муу байгаа нь тайрдас зурсанаар харагдаж байна. Гэхдээ энэ хүн яг болж байгаа үйл явдлыг эргэцүүлэх чадвартайгаас гадна болж буй байдлыг мэдрэх чадвартай. Ийм сэтгэлзүйн онцлогтой хүмүүс тодорхой бус, гэр бүл ямар байх талаар ойлголтгүй хүмүүс байна.

Нийслэлчүүдийн гэр бүлийн хэв дотор ардчилсан хэв саяг давамгайлах болжээ. Гэр бүлийн хэв маягт нийгмийн нөлөө илүү давамгай болох боловч сэтгэл зүйн хүчин зүйлийг заавал тооцох хэрэгтэй байна.

Эцэст дүгнэж үзэхэд, ардчилал, даяаршил, орчин, нийгмийн хөгжил, соёл зэрэгтэй холбоотойгоор судалгаанд оролцсон гэр бүлийн тухайд уламжлалт гэр бүлийг харилцан тэгш эрхт гэр бүлээр солих, гэр бүлийн бүх гишүүд гэр бүлийн ажлуудыг хамтдаа хийж, өрхийн тэргүүн ганцаараа шийдвэр гаргадаг нь багасаж ардчилсан, хамтач гэр бүл илүү болсон нь харагдаж байна.

Ном зүй

1. Белый Б. Диагноз по чернильным кляксам. М., 2010
2. Бүрэнжаргал Т. Гэр бүлийн социологи. УБ., 2005
3. “Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” суурь судалгаа. УБ., 2004
4. Намжил Т. Монгол гэр бүл. УБ., 2006
5. Хүн ам, орон сууцны тооллогын үндсэн үр дүн. ҮСХ, 2010